

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|----------------------------|-----------|------|
| 376. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 55 | 1605 |
| 377. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 56 | 1606 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|------------|------|
| 378. | Жагсаалт батлах тухай | Дугаар 303 | 1606 |
| 379. | Зарим компанийн согтууруулах ундаа
үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг шинэчлэн
олгох, хүчингүй болгох тухай | Дугаар 310 | 1610 |
| 380. | Журамд нэмэлт оруулах тухай | Дугаар 311 | 1611 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 55

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

3. ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 56

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэллэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 8 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 303

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙД

С.ОЮУН



Засгийн газрын 2013 оны 303 дугаар
тогтоолын хавсралт

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ХЭМНЭЛТТЭЙ АШИГЛАХ, ОРЧНЫ
БОХИРДОЛ, ХАЯГДЛЫГ БАГАСГАХ, БАЙГАЛЬД ХАЛГҮЙ
ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

№	БТКУС-ийн код	Тоног, төхөөрөмжийн нэр
1	8421.21.00	Бохир ус цэвэрлэх төхөөрөмж
2	8541.40.00	Эрчим хүчний хэмнэлттэй гэрлийн шил (light-emitting diode буюу LED-тай)
3	8539.39.00	Эрчим хүчний хэмнэлттэй гэрлийн шил (cold cathode fluorescent буюу CCF-тай)
4	3917.39.00	Дуслын усалгааны гуурс, хоолой, шланг
5	7321.19.00	Гэрийн зуух (EN 13240 стандартын шаардлага хангасан)
6	8405.10.00	Автомашины түлш, утаа бууруулах устөрөгчийн генератор
7	8507.80.00	R-290 (Propane) бүхий хөргөлтийн тоног төхөөрөмж
8	8703.90.31	R-32 (Difluoromethane) бүхий хөргөлтийн тоног төхөөрөмж
9	8703.90.32	R-152a (Difluoroethane) бүхий хөргөлтийн тоног төхөөрөмж
10	8703.90.33	R-744 (Carbon dioxide) бүхий хөргөлтийн тоног төхөөрөмж
11	8405.10.00	Модны үртэс, зоргодос, целлюлозон ширхэглэлийг шахаж зоргодсон, эслэг хавтан хийх төхөөрөмж

12	8703.90.70	Цэцэрлэгийн аж ахуй болон ойн аж ахуйн хөрс бэлтгэх, боловсруулах төхөөрөмж
13	2711.12.00	Цахилгаан хөдөлгүүр (3-10 кВт хүчин чадалтай)
14	2903.39.90	Цахилгаан хөдөлгүүр (85-180 кВт хүчин чадалтай)
Салхин цахилгаан үүсгүүрийн иж бүрдэл		
15	6810.91.50	Салхин цахилгаан үүсгүүрийн төмөр-бетонон багана
16	7308.20.00	Салхин цахилгаан үүсгүүрийн ган цамхаг, түүнийг холбогч эд анги (фланц)
17	8412.80.10	Салхин турбин
18	8412.90.10	Салхин турбины эд анги (сэнс, далбаа)
19	8502.31.00	Салхин цахилгаан үүсгүүр
Нарны цахилгаан үүсгүүрийн иж бүрдэл		
20	3920.10.00	Этилен-винил-ацетат хуудас (EVA- Ethylene vinyl acetate film)
21	3920.99.00	Поливинилфторид хуудас (Tedlar- Polyvinyl fluoride film)
22	7003.12.00	Нарны зайн нүүрний шил
23	7410.11.00	Нарны элемент холбох зориулалттай, тугалган бүрээстэй зэс тууз
24	7610.90.00	Нарны зайн хөнгөн цагаан хүрээ



25	85.01	Нарны цахилгаан үүсгүүр
26	8504.40.00	Хүчдэл хувиргагч (инвертор)
27	85.37	Нарны цахилгаан үүсгүүрийн цэнэг зохицуулагч (контролер)
28	8541.40.00	Нарны элемент
Нарны коллектор, халаалтын иж бүрдэл		
29	7411.10.00	Нарны коллекторын дулаан дамжуулах зэс хоолой
30	8307.90.00	Нарны коллекторуудын холболтын зориулалттай дулааны хоолой бүхий вакуум коллектор
31	8419.19.00	Нараар ус халаах зориулалттай дулааны хоолой бүхий вакуум коллектор, хавтгай коллектор
32	8481.40.00	Нарны коллектороор ус болон барилга халаах системийн даралт, температурын хамгаалалтын хавхлага
33	9032.81.00	Нарны коллектороор ус болон барилга халаах системийг дүүргэх, температур, даралт, шингэний зарцуулалтыг хэмжих, системийг хамгаалах хавхлага бүхий төхөөрөмж
34	9032.89.00	Нарны коллектороор ус болон барилга халаах системийн антифрийз, халуун усны температурыг хэмжих, нөөц эх үүсвэр залгах автомат төхөөрөмж



Усан болон усан цэнэгт цахилгаан станцын тоног төхөөрөмж		
35	8410.11.00	1.000 кВт-аас ихгүй хүчин чадалтай
36	8410.12.00	1.000 кВт-аас их боловч 10.000 кВт-аас ихгүй хүчин чадалтай
37	8410.13.00	10.000 кВт-аас их хүчин чадалтай
38	8413.81.00	Гидронасос
39	8502.39.00	Гидрогенератор
40	9026.10.00	Усны түвшин болон урсац хэмжигч, монометрууд
41	8414.80.00	Газрын гүний дулааны насос

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 9 дүгээр
сарын 6-ны өдөр

Дугаар 310

Улаанбаатар
хот

**Зарим компанийн согтууруулах ундаа
үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг шинэчлэн
олгох, хүчингүй болгох тухай**

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, аж ахуйн нэгжийн хүсэлт болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны саналыг үндэслэн Сэлэнгэ аймгийн Зүүнхараа дахь “Спирт бал бурам” ХХК-ийн спирт, архи үйлдвэрлэх



тусгай зөвшөөрлийг Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт, Улаанбаатар хотын Баянгол дүүргийн “Арвайн үндэс” ХХК-ийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг Сонгинохайрхан дүүрэгт тус тус шинэчлэн олгосугай.

2. “Мөнх Монгол” ХХК-ийн саналыг үндэслэн “Мөнх Монгол” ХХК-ийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД

Х.БАТТУЛГА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 9 дүгээр
сарын 6-ны өдөр

Дугаар 311

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт оруулах тухай

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 185 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмад настанд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 2 дахь хэсэгт дор дурдсан агуулга бүхий 2.26. дахь заалт нэмсүгэй:

“2.26. Ахмадын зориулалттай амралт, сувиллын газарт амарч сувилуулах эрхийн бичгийн үнийг урьдчилан бүрэн төлөх боломжгүй ахмад настан энэхүү журмын 3.3-т заасан баримт бичиг болон нэхэмжлэлийг сум, хорооны нийгмийн ажилтанд бүрдүүлэн өгсөн тохиолдолд хөнгөлөлтийг

нийгийн халамжийн сангаас тухайн амралт, сувиллын байгууллагын дансанд шилжүүлж болно.”

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

С.ЭРДЭНЭ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн худас: 0.5

Индекс: 14003